



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 7/351

Есөнбулаг

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай", Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга, хот, байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Есөнбулаг сумын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зарлан явуулах газрын хэмжээ, зориулалт, дуудлага худалдааны анхны үнийг 1 дүгээр хавсралтаар, байршлыг 2-3 дугаар хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газруудад архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж мөрдүүлэхийг аймгийн ерөнхий архитектор (Б.Бямбадорж)-т, дуудлага худалдааг 2024 оны 07 дугаар сарын 05-ний өдөр цахимаар зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зориулалтаар
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар: 3748998

Хаяг: Говь-Алтай аймаг, Есенбулаг сум, Харзат баг, Морь барманы хойд талд

Аймгийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
0/33 дугаар захирамжийн 2-р хавсралт



Огноо: 2024-05-16

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|--------|-------------|------------|-------|--------|
| 1 | 5143398.785 | 294207.474 | 50.00 | 1-2 |
| 2 | 5143448.190 | 294215.170 | 60.00 | 2-3 |
| 3 | 5143438.955 | 294274.455 | 50.00 | 3-4 |
| 4 | 5143389.551 | 294266.750 | 59.99 | 4-1 |

Талбайн хэмжээ: 3000.0 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зориулалтаар
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар: 3765999


Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг, Нарны станцын урьд талд



Огноо: 2024-05-16

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Урт | Цагүүд |
|--------|-------------|------------|--------|--------|
| 1 | 5144271.784 | 294824.366 | 285.71 | 1-2 |
| 2 | 5144391.171 | 294564.791 | 350.00 | 2-3 |
| 3 | 5144709.151 | 294711.041 | 285.71 | 3-4 |
| 4 | 5144589.764 | 294970.616 | 350.00 | 4-1 |



Талбайн хэмжээ: 100000.0 квадрат метр

Зургийн масштаб 1:6 000 (1 сантиметрт 60 метр багтана)

